

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

АЙМГИЙН БОЛОВСРОЛ, СОЁЛ УРЛАГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ТАНИЛЦУУЛГА, ЗӨВЛӨМЖ

2018.06.25

Чойр

Нэг. Удиртгал

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”, 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”, аймгийн Засаг даргын 2017 оны А/264 дүгээр захирамжаар батлагдсан “Баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэл болгон аймгийн Засаг даргын 2018 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн батлагдсан удирдамжийн дагуу боловсролын салбарын байгууллагуудын дотоод үйл ажиллагаанд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийж энэхүү ажлын үр дүнг танилцуулж байна.

1.1. Хамрах хүрээ, ерөнхий мэдээлэл

Боловсрол, соёл урлагийн газар, 5 сургууль, 5 цэцэрлэгийн дотоод үйл ажиллагаа, аймгийн Засаг дарга сумын Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилт, баримт бичгийн төлөвлөлт болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэнд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

1.2. Багийн бүрэлдэхүүн

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хэлтсийн дарга Х.Буянбаяр, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн П.Наранмандах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн Б.Өлзийдэлгэр нар ажиллав.

1.3. Арга, аргачлал

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол, 2015 оны 483 дугаар тогтоол, 2017 оны 89 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2017 оны А/264 дүгээр захирамж, холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгон үр дүнд суурилсан явцын үнэлгээг төлөвлөгөө, судалгаа, тайлан мэдээнд үндэслэн гүйцэтгэв.

1.4. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Боловсрол, соёл урлагийн газрын харьяа байгууллага тус бүрээр орж үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэллээ. Үүнд:

2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний явц, үр дүн

Боловсрол, соёл урлагийн газар, 5 сургууль, 5 цэцэрлэгийн дотоод үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын үр дүнг байгууллага тус бүрээр танилцуулж байна. Үүнд:

1. БОЛОВСРОЛ, СОЁЛ УРЛАГИЙН ГАЗАР :

Боловсрол, соёл урлагийн газар нь 2017-2018 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролын улсын 5 цэцэрлэг, сургууль, хувийн хэвшлийн 5 цэцэрлэг, соёл урлагийн 5 байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Сургуулийн өмнөх боловсролын 1,2,3,4,5-р цэцэрлэг
- Ерөнхий боловсролын 1,2,3,4,5-р сургууль
- Соёл урлагийн байгууллага: Боржигин чуулга, Нийтийн номын сан, Боржигин өв музей, Баянтал сумын соёлын төв, Шивээговь сумын соёлын төв
- Политехникийн коллеж

Боловсрол, соёл урлагийн газар нь боловсрол, соёл урлагийн талаарх төрийн бодлогыг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэхтэй холбогдуулан боловсролын салбарын байгууллагуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэх, багш, сурган хүмүүжүүлэгчдийн мэргэжлийг дээшлүүлэх, тэднийг мэргэжлийн онол, арга зүйн мэдээллээр хангах үйл ажиллагааны үндсэн чиглэлтэй ажиллаж байна.

2017-2018 оны хичээлийн жилд улсын 5 цэцэрлэг, хувийн 5 цэцэрлэгийн 51 бүлэгт 1800 хүүхэд хамрагдаж, үндсэн 44 багш, туслах 42 багш, нийт 86 багш ажиллаж байна.

Ерөнхий боловсролын бага боловсролд 61 бүлэгт 1802 суралцагч, 61 багш, суурь боловсролд 44 бүлэгт 1091 суралцагч, 78 багш, бүрэн дунд боловсролд 20 бүлэгт 507 суралцагч 40 багш нийт 125 бүлэгт 3400 суралцагч суралцаж, 179 багш ажиллаж байна. Нийт багш нарын 11,1 хувь тэргүүлэх зэрэгтэй, 32,4 хувь нь заах аргач зэрэгтэй байна.

Боловсрол, соёл урлагийн газар нь 2018 онд 8 орон тоотой, 125,2 сая төгрөгийн батлагдсан төсөвтэй ажиллаж байна.

2018 онд аймгийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээг 5 зорилтын хүрээнд 122 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 2018.04.20-ны өдөр байгуулжээ.

Байгууллагын дотоод үйл ажиллагаандаа хөдөлмөрийн дотоод журам, дотоод хяналт шалгалтын журмыг боловсруулан мөрдөж байна.

Боловсрол, соёл урлагийн газрыг 2017-2020 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөөндөө тулгуурлан 2017-2018 оны хичээлийн жилийн төлөвлөгөө, жилийн ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.

Байгууллагын ололттой тал:

1. Боловсрол, соёл урлагийн газар нь 2017-2018 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролын хүрээнд шилдэг аргазүй технологийг бий болгох, хамтран ажиллах харилцан туршлага солилцох зорилгоор 45 багшийн дунд арга

зүйн судалгааг явуулж, гарсан саналыг нэгтгэж, судалгааны үр дүнд бий болсон сургалтын шилдэг 7 хөтөлбөрийг нэгтгэн цэцэрлэгүүдэд гардуулж өгсөн.

2. Орон нутагт “Тогтвортой хөгжил- сургуулийн өмнөх боловсрол” зөвлөгөөнийг зохион байгуулсан.

3. 2018.06.18-наас “Сувиллын цэцэрлэг” ажиллуулахаар төлөвлөсөн байна.

4. Боловсролын чанарын шинэчлэл төсөл – 30,0 сая төгрөгөөр хэрэгжиж “STEM” хөтөлбөрийн сургалтын хэрэглэгдэхүүнээр хангагдаж, сургалт зохион байгуулах орчин нөхцөл бүрдсэн:

Суурь, ахлах боловсролын хүрээнд:

5. Ахмад багшийн зөвлөх үйлчилгээ” төслийг хэрэгжүүлэн СӨБ, суурь, ахлах боловсролын чиглэлээр нийт 8 ахмад багшийг хамруулан 640 цагийн зөвлөх үйлчилгээг аймгийн ерөнхий боловсролын 5 сургуулийн хими, биологи, математик, физик, монгол хэл, гадаад хэлний багш нарт хүргэсэн.

6. УИХ-ын гишүүн Г.Мөнхцэцэгийн санаачилсан “Их соёл- эх үндэс” хөтөлбөрийн хүрээнд багш нарын ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр МУБИС-ийн эрдэмтэн багш нарын багийг урьж сургалт явуулж, арга зүйгээр хангаж ажилласан.

7. Ерөнхий шалгалт-2018 ажлын хүрээнд нэгдсэн төлөвлөгөө гаргаж судлагдахуун бүрээр аймгийн мэргэжлийн багийн ахлагч нарыг томилон, сорилго шалгалтыг 2 удаа зохион байгуулсан.

8. Соёл, урлагийн ажилтны манлайлал, мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалт зөвлөгөөнийг зохион байгуулж 80 албан хаагчийг хамруулсан.

9. “Хөгжмийн эгшиг-2018” бүсийн уралдааныг орон нутагт зохион байгуулсан. Уралдаанд гадны 4 аймгийн 9 сум буюу нийт 168 хүүхэд, 20 багш оролцсон.

Дутагдалтай талууд:

Байгууллагын дотоод үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийхэд дараах алдаа дутагдлууд гарч байна.

1. Бодлогын баримт бичгүүдийн холбогдох зорилт арга хэмжээг хяналтанд авч эзэнжүүлээгүй, төлөвлөлт хийгдээгүй.

2. Төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээг 2 албан хаагчтай байгуулаагүй / математик, статистик хариуцсан мэргэжилтэн нь ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ тавьсан, төсвийн мэргэжилтэн шинээр томилогдсон учраас гэрээ байгуулаагүй /

3. Байгууллагын албан хаагчдын ажил үүргийн хуваарийг тэнцвэржүүлээгүй, ажлын байрны тодорхойлолтыг батлаагүй.

4. Тушаал гаргахдаа холбогдох хуулийн заалтыг оновчтой үндэслээгүй, утга найруулгын алдаатай.

5. Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журмаа ЗГ-ын 2017 оны 89-р тогтоолоор батлагдсан журмын хүрээнд шинэчилж боловсруулаагүй

6. Сургууль, цэцэрлэгийн 2017 оны жилийн эцсийн үйл ажиллагаанд ХШҮ хийгээд зөвлөмж хүргүүлээгүй, ХШҮ-ний үр дүнг тооцдоггүй.

7. Сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ бодлогын баримт бичгийн төлөвлөлт, хэрэгжилт, тушаалын эрх зүйн үндэслэл, бичиг хэрэг хөтлөлт, албан хаагчдын хувийн хэрэг бүрдүүлэлт, ажлын байрны тодорхойлолт зэрэгт үнэлгээ хийдэггүй учраас тухайн байгууллагуудад дээрх үйл ажиллагаатай холбоотой нийтлэг алдаа дутагдал гарсан байна.

8. Байгууллагын цахим хуудасны мэдээлэл дутуу оруулсан байсан

2. ПОЛИТЕХНИКИЙН КОЛЛЕЖ

Ололттой тал:

Хөдөлмөрийн дотоод журам, хамтын гэрээг шинэчлэн боловсруулж батлуулсан байна. Нийт 87 багш, ажилтан бүртэй хөдөлмөрийн гэрээ байгуулж, жилийн эцэст захирлын зөвлөлийн хурлаар хүн бүрээр тайлан хамгаалуулж, гэрээний хэрэгжилтийг дүгнэн хэлэлцүүлдэг, бүх багш, ажилтан нарын ажлын байрны тодорхойлолт бүрэн чиг үүргийг тодорхой тусгаж баталсан. Дотоод хяналт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэнтэй.

Дутагдалтай тал:

2012.08.25-ны өдрийн захирлын 67 дугаар тушаалын хавсралтаар 28 журам баталсан. Байгууллагын дотоод үйл ажиллагаандаа эдгээр 28 төрлийн журмыг мөрдөн ажиллаж байна. Журмуудын боловсруулалтыг үзэхэд үйл ажиллагааны чиглэл давхардсан, журам батлах эрх зүйн үндэслэл буруу, холбогдох хуулийн зүйл заалтыг үндэслээгүй зэрэг алдаа байсныг илрүүлж зөвлөлөө.

3. СҮМБЭР СУМЫН 1 ДҮГЭЭР СУРГУУЛЬ

2017-2018 оны хичээлийн жилд нийт 78 ажилтан албан хаагч, 1120 сурагчтай, 1053210,3 мянган төгрөгийн батлагдсан төсөвтэй үйл ажиллагаа явуулж байна. Нийт ангийн 50 хувь ухаалаг самбартай

Аймгийн Засаг даргаас Боловсрол, соёл урлагийн газрын дарга, нэгдүгээр сургуулийн захирлын хооронд гурвалсан гэрээг 5 зорилт 49 арга хэмжээтэй байгуулсан.

Шинээр санаачилсан ажлаас дурдвал:

- ✚ Шатрын дугуйланд 1-6 дугаар ангийн бүх хүүхдүүд хамрагддаг.
- ✚ 6,10 дугаар ангидаа математикийн гүнзгий анги хичээллүүлсэн.
- ✚ Япон улсын Нагаяо их сургуультай хамтран ажиллах, судалгаа аргазүйн түшиц сургууль болох боломжоор хангагдсан.

2017 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын ажил

- ✚ Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр “Байгалийн ухааны кабинет” 3000 долларын хөрөнгө оруулалт
- ✚ ДЗОУБ-аас биеийн тамирын хичээлийн хэрэглэгдэхүүнүүд, иж бүрэн 8 хос ширээ, сургалтын танхимын ширээ сандал, ус цэвэршүүлэгчтэй ус буцалгагч
- ✚ Номын сангийн фонд баяжуулах 1,0 сая төгрөгийн төсөл

Ололттой тал:

Хөдөлмөрийн гэрээг маш нарийн тодорхой болгож бүх багш, ажилчидтай байгуулсан. Хөдөлмөрийн гэрээг нарийн шалгуур үзүүлэлтээр дүгнэж урамшуулал олгодог. Сургуулийн хэтийн төлөвлөгөөг шинэчилсэн. Төлөвлөлтийг нарийн

оновчтой шалгуур үзүүлэлтийг хэмжиж болохуйц тоогоор илэрхийлсэн. Жилийн ажлын календарчилсан төлөвлөгөө гаргаж хөтөлсөн.

Сургуулийн 70 хувь хяналтын камерт бүрэн холбогдож нийт ангийн 50 хувь нь ухаалаг самбартай болсон.

Дутагдалтай талууд:

Ажилчдын хувийн хэргийн бүрдүүлэлт дутуу
Төрийн албан хаагчийн сургалт хөтөлбөр баталж, хэрэгжүүлээгүй

4. СҮМБЭР СУМЫН 2 ДУГААР СУРГУУЛЬ

2017-2018 оны хичээлийн жилд 58 ажилтан, албан хаагч, 608 сурагчтай, 797910,7 мянган төгрөгийн батлагдсан төсөвтэй үйл ажиллагаа явуулж байна.

Аймгийн Засаг даргаас Боловсрол, соёл урлагийн газрын дарга, нэгдүгээр сургуулийн захиралын хооронд гурвалсан гэрээг 5 зорилт 53 арга хэмжээтэй байгуулсан.

2017 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын ажил

✚ Дэлхийн банкны санхүүжилтээр 7,0 сая төгрөгийн “Бид бяцхан ургамал судлаачид” гэсэн төсөл

✚ БСШУЯамны санхүүжилтээр STEM сургалтын хэрэглэгдэхүүн 4,833,2 мянган төгрөгийн

✚ БСШУЯамны Чанар шинэчлэлтийн төслийн хүрээнд STEM сургалтын ширээ сандал 2352,0 мянган төгрөгийн

✚ Сумын ОНХСангаас 10,0 сая төгрөгөөр 32 ширхэг хяналтын камер хийгдсэн.

Ололттой тал:

Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, сургалт хөтөлбөрийг баталж төлөвлөгөө гаргасан.

Сургуулийн үйлчилгээний чанар, хүртээмжийн гүйцэтгэлийг сайжруулах төлөвлөгөөг баталсан.

2017-2018 оны хичээлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө нь 3 зорилт 38 хэрэгжүүлэх арга хэмжээтэй календарчилсан төлөвлөгөө гаргаж хөтөлсөн.

Дутагдалтай талууд:

1. Ажлын байрны тодорхойлолтыг шинэчилж батлаагүй.
2. Төрийн албан хаагчийн хувийн хэргийн бүрдэл дутуу
3. Төлөвлөгөөний арга хэмжээ бүрийн хүрэх үр дүн тодорхойлоогүй
4. Тушаалд холбогдох хуулийн зүйл заалтыг оновчтой үндэслээгүй
5. Өөрийн хүсэлтээрээ тэтгэвэрт гарч, тэтгэмжээ авсан ажилтныг ажилд буцаан томилсон.
6. Бодлогын баримт бичгүүдээс хамааралтай холбогдох зорилт, арга хэмжээг хяналтанд аваагүй, тайлагналт гараагүй байна. Тухайлбал ЗГ-ын 2017 оны 01 албан даалгавар, аймгийн Засаг даргын 03 тоот албан даалгаврын хэрэгжилтийг тайлагнаагүй байна.

5. ШИВЭЭГОВЬ СУМЫН 3 ДУГААР СУРГУУЛЬ

2017-2018 оны хичээлийн жилд 679 сурагч, 53 багш, ажилчидтай 779389,1 мянган төгрөгийн батлагдсан төсөвтэй үйл ажиллагаа явуулж байна.

Аймгийн Засаг даргаас Боловсрол, соёл урлагийн газрын дарга, гуравдугаар сургуулийн захирлын хооронд гурвалсан гэрээг 5 зорилт 62 арга хэмжээтэй байгуулсан.

2017 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын ажил

✚ 2017 онд сургуулийн 1,3 дугаар корпусын дээвэр, урлаг заал, спорт заалны дээврийг орон нутаг хөгжүүлэх сангийн 107,0 сая төгрөгөөр засварласан.

✚ Сургуулийн дээврийн төмрийг Орон нутгийн өмчийн газраас зарж борлуулах эрхийг хүсэж, журмыг үндэслэн борлуулснаар 760,0 мянган төгрөгийг олж түүн дээр өөрийн дотоод нөөц боломжоор дотуур байрны 4 тасаг, коридор, Хүүхдийн хөгжлийн төв, Багшийн хөгжлийн төв, номын сан зэргийг 5,0 сая гаруй төгрөгөөр засварлалаа.

✚ Улсын их хурлын гишүүн Г.Мөнхцэцэгийн дэмжлэгээр БСШУСЯ-наас дотуур байрны гал тогооны иж бүрэн тоног төхөөрөмж /цахилгаан пийшин, хөлдөөгч, буузны жигнүүр, бэлтгэх ширээ, аяга таваг ариутгагч / нийт 4411,0 мянган төгрөгийн тохижилт хийсэн. Бага ангийн байгалийн ухааны “Бяцхан судлаач” төсөл хэрэгжиж иж бүрэн кабинеттай болсон.

✚ Дэлхийн банк, БСШУСЯ-ны хөрөнгө оруулалт 7350,0 мянган төгрөгөөр бага ангийн байгалийн ухааны “Бяцхан судлаач” төсөл хэрэгжиж иж бүрэн кабинеттай боллоо.

✚ БСШУСЯ-ны “Чанарын шинэчлэл” төслийн хүрээнд STEM сургалтын танхимын ширээ сандал, номын тавиур зэрэг 2688,0 мянган төгрөгийн, 1994,0 мянган төгрөгийн сургалтын хөтөлбөртэй STEM төсөл хэрэгжсэн.

Шинээр санаачилсан ажил:

- Сахилга хариуцлагыг дээшлүүлэх хүрээнд сар бүрийн 2 дахь 7 хоногийн 5 дахь өдрийг хууль судлах өдөр болгож, багш, ажилчдаа багийн системд оруулж, баг тус бүр бусдадаа судалсан хуулийнхаа талаар мэдээлэл хийж, ярилцдаг.
- “Эвдрэлгүй” анги хамт олныг шалгаруулах уралдаан зарлаж шилдэг ангид нь урамшуулал олгож, зөрчилтэй ангид нь зөвлөмж хүргэж зөрчлийг арилгуулдаг.
- “Зөвлөх багш зөвлөж байна” бүсийн чуулга уулзалтыг зохион байгуулсан.
- Хүүхдийн нэгдсэн чуулга уулзалтыг жил бүр уламжлал болгон явуулдаг. 2017 онд УБ хотын 48-р сургуультай хамтран өртөөчилсөн сургалт зохион байгуулж, 1700,0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт татаж авсан. Хөрөнгө оруулалтыг орон нутгийн удирдлага, Шивээ овоо ХХК хийсэн.

Ололттой тал:

Бодлогын баримт бичгүүдээс холбогдолтой зорилт арга хэмжээг хяналтанд авч эзэнжүүлсэн. Тайлагналт сайн.

Дотоод хяналтын сайн хэрэгжүүлдэг. Үдийн цай хөтөлбөрт эцэг, эхийн хяналтыг тогтмол тавиулдаг. Дотуур байрны хоолны чанар байдалд сар бүр дотоод хяналтыг хийж хэвшсэн байна. Дотоод хяналтын гишүүн бүр төлөвлөгөө гаргасан. 5 ажилд дотоод хяналт хийж ажилласан.

Сургуулийн багш, ажилтан бүртэй хөдөлмөрийн гэрээ байгуулсан.

Хариуцлагын жилийн ажлын төлөвлөгөө гаргаж баталсан.

Жилийн ажлын календарчилсан төлөвлөгөө гаргаж хөтөлсөн.

Дутагдалтай талууд:

1. Дотоод хяналтыг хийхдээ нэгдсэн төлөвлөгөө гаргаж батлуулсан хирнээ арга хэмжээ тус бүрт удирдамжгүй гүйцэтгэсэн.
2. Ажлын байрны тодорхойлолтыг дахин боловсруулах, шинэчлэх
3. Багш, ажилчдын хувийн хэргийн бүрдэл дутуу
4. Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, сургалт хөтөлбөргүй, төлөвлөгөөгүй байсан.

6. БАЯНТАЛ СУМЫН 4 ДҮГЭЭР СУРГУУЛЬ

2017-2018 оны хичээлийн жилд 134 сурагч, багш ажилчидтай 436587,6 мянган төгрөгийн батлагдсан төсөвтэй үйл ажиллагаа явуулж байна.

Аймгийн Засаг даргаас Боловсрол, соёл урлагийн газрын дарга, дөрөвдүгээр сургуулийн захирлын хооронд гурвалсан гэрээг 5 зорилт 55 арга хэмжээтэй байгуулсан.

2017 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын ажил

- ✚ ОНХСангийн хөрөнгөөр сургуулийн дотуур байранд 54,0 сая төгрөгийн их засварын ажил хийгдсэн.
- ✚ 2017 онд сургуулийн спорт заалны цахилгааны их засвар 8,8 сая төгрөгөөр хийгдсэн.
- ✚ 2017 онд сургуулийн спорт заалны их засварын ажил 40,0 сая төгрөгөөр хийгдсэн.
- ✚ 2018 онд сумын ОНХСангаас 10325,0 мянган төгрөгөөр зөөлөн эдлэл, ширээ, сандлыг, Хандив тусламжаар 1790,0 мянган төгрөгөөр ширээ сандал, яамны хөрөнгө оруулалтаар 375,0 мянган төгрөгөөр ширээ, сандал, шкаф, тавиур, самбар зэрэг ажлууд хийгдсэн.

Дутагдалтай талууд:

1. Бодлогын баримт бичгүүдээс хамааралтай холбогдох зорилт, арга хэмжээг хяналтанд авч эзэнжүүлээгүй, тайлагналт хангалтгүй байсан.
2. Дотоод хяналтыг хийхдээ батлагдсан удирдамжгүй, гүйцэтгэлийн илтгэх хуудасгүй, илэрсэн зөрчлийг арилгах зөвлөмж гаргаагүй дотоод хяналтын бүртгэлийн дэвтэрт хөтлөлт хийсэн.
3. Тушаал гаргахдаа холбогдох хуулийн зүйл заалтыг оновчтой үндэслээгүй, хөрөнгө зарцуулах, ур чадварын нэмэгдэл олгох шийдвэртээ Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслээгүй, ЗГ-ын тогтоолоор хөрөнгө зарцуулж, ур чадварын нэмэгдэл олгосон, хариуцлагатай жижүүр томилох тушаал гаргахдаа МУ-ын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “л” хэсгийг буюу аймгийн Засаг даргын бүрэн эрхийн заалтыг үндэслэн шийдвэр гаргасан.
4. Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөргүй, сургалт зохион байгуулах төлөвлөгөө, гүйцэтгэлгүй.
5. Багш, ажилчдын ажлын байрны тодорхойлолт нь албан тушаалын шаардлагыг хангаагүй.

7. СҮМБЭР СУМЫН 5 ДУГААР СУРГУУЛЬ

2017-2018 оны хичээлийн жилд 905 сурагч, 70 багш ажилчидтай, 113355,8 мянган төгрөгийн батлагдсан төсөвтэй үйл ажиллагаа явуулж байна.

Ололттой тал:

Хичээлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө зорилт батлагдсан. Төлөвлөлтөд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хэрэгжүүлэх сарууд, хамрах хүрээ, хариуцах эзэн зэргийг оруулсан төлөвлөлт сайн.

БСШУЯамны сайдтай 5 дугаар сургуулийн захирал 2018 онд хамтран ажиллах үр дүнгийн гэрээг 16 зорилтын 44 арга хэмжээтэй байгуулсан байна.

Гэрээний хэрэгжилтийг хангах жилийн ажлын төлөвлөгөөг хичээлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулсан.

Дутагдалтай талууд:

1. Ажлын байрны тодорхойлолтыг батлаагүй,
2. Багш, ажилчдын хувийн хэргийн бүрдэл дутуу, баяжилт хийгдээгүй
3. Дотоод хяналтыг хэрэгжүүлэхдээ удирдамж батлуулаагүй, гүйцэтгэлийн илтгэх хуудас бичээгүй байна. /Дотуур байрны сурагчдын хоол, хүнс, сурагчдын ирцэнд дотоод хяналт хийсэн гэх/
4. Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, сургалт хөтөлбөрийн төлөвлөгөө боловсруулж, тайлагнаагүй
5. Тушаал гаргахдаа холбогдох хуулийн зүйл заалтыг оновчтой үндэслээгүй, хөрөнгө зарцуулах тушаалдаа Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслээгүй байна.

8. СҮМБЭР СУМЫН 1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГ

2017-2018 онд хичээлийн жилд 360 хүүхэд, 31 багш, ажилчидтай 427107,1 мянган төгрөгийн батлагдсан төсөвтэй үйл ажиллагаа явуулж байна.

Аймгийн Засаг даргаас Боловсрол, соёл урлагийн газрын дарга, нэгдүгээр цэцэрлэгийн эрхлэгчийн хооронд гурвалсан гэрээг 5 зорилт 45 арга хэмжээтэй байгуулсан.

Дутагдалтай талууд:

1. Ажлын байрны тодорхойлолт ажилтан бүрээр боловсруулагдсан ч хангалтгүй байна. Тухайн албан тушаалд тохируулж шинэчлэн боловсруулаагүй
2. Байгууллагын багш, ажилчдын хувийн хэргийн бүрдэл дутуу.
3. Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгаа хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөгүй.
4. Төрийн албан хаагчдын сургалт хөтөлбөрийн 2018 оны төлөвлөгөөгүй
5. Бодлогын баримт бичгээс хамааралтай зорилт арга хэмжээг хяналтанд аваагүй, тайлагнаагүй.
6. Тушаал гаргахдаа холбогдох хуулийн зүйл заалтыг оновчтой үндэслээгүй, утга найруулгын алдаатай, албан хэрэг хөтлөлтийн стандарт хангагдаагүй.

9. СҮМБЭР СУМЫН 2 ДУГААР ЦЭЦЭРЛЭГ

2 дугаар цэцэрлэг нь 1988 онд байгуулагдсан 144 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай. 2017-2018 оны хичээлийн жилд 6 бүлэг 210 хүүхэд, 23 багш ажилчдын хамт үйл ажиллагаагаа явуулж байна.

Аймгийн Засаг даргаас Боловсрол, соёл урлагийн газрын дарга, хоёрдугаар цэцэрлэгийн эрхлэгчийн хооронд гурвалсан гэрээг 5 зорилт 45 арга хэмжээтэй байгуулсан.

2017 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын ажил:

Цахилгааны их засварыг “Сүмбэр старлет” ХХК 56,0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.

Шинээр санаачилсан ажил:

Хэл ярианы чиглэлээр 3 жил дараалан уламжлал болгон сургалт арга зүйг явуулж ирсэн. Сургалтын хүрээнд хэл ярианы арга зүйн судалгааны материал боловсруулсан.

Ололттой тал:

2017-2018 оны хичээлийн жилийн ажлын төлөвлөгөөг нарийн оновчтой шалгуур үзүүлэлтийг хэмжиж болохуйц тоогоор илэрхийлсэн. Багш, ажилчидтай хөдөлмөрийн гэрээг байгуулж, гэрээг жилийн эцэст дүгнэж урамшуулал олгодог.

Сургалтын цөм хөтөлбөрийн хүрээнд цэцэрлэгийн дүрмийг боловсруулж баталсан байна.

Сахилга хариуцлага дэг журмыг чангатгах жилийн ажлын төлөвлөгөө гаргаж багш, ажилчдад танилцуулж тэмдэглэл хөтөлсөн.

Дотоод хяналтыг тогтмол хэрэгжүүлдэг. Өдөр бүр хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа зааварчилгаа өгч тэмдэглэл хөтөлж гарын үсэг зуруулдаг.

Дутагдалтай талууд:

1. Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа дууссан. 2018 оны төлөвлөгөөгөө 9 арга хэмжээтэйгээр төлөвлөсөн.

10. БАЯНТАЛ СУМЫН 4 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГ

2017-2018 оны хичээлийн жилд 102 хүүхэд, 13 багш, ажилтантай 167369,9 мянган төгрөгийн батлагдсан төсөвтэй үйл ажиллагаа явуулж байна.

Аймгийн Засаг даргаас Боловсрол, соёл урлагийн газрын дарга, дөрөвдүгээр цэцэрлэгийн эрхлэгчийн хооронд гурвалсан гэрээг 5 зорилт 45 арга хэмжээтэй байгуулсан.

Дутагдалтай талууд:

1. Ажлын байрны тодорхойлолт нь багш бүр нэгэн ижил, албан тушаал бүрт ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах шаардлагатай.

2. Багш, ажилчдын хувийн хэргийн бүрдэл дутуу, хувь хүний намтар буруу бичигдсэн.

3. Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах болон ТАХ-ийн сургалт хөтөлбөргүй.

4. Тушаал гаргахдаа холбогдох хуулийн зүйл заалтыг оновчтой үндэслээгүй, хөрөнөг зарцуулах, ур чадварын нэмэгдэл олгох шийдвэртээ Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслээгүй, ЗГ-ын тогтоолоор хөрөнгө зарцуулж, ур чадварын нэмэгдэл олгосон, хариуцлагатай жижүүр томилох тушаал гаргахдаа МУ-ын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “л” хэсгийг буюу аймгийн Засаг даргын бүрэн эрхийн заалтыг үндэслэн шийдвэр гаргасан.

5. Хичээлийн жилийн төлөвлөлт нь шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин нь тодорхойгүй байсан.

11. СҮМБЭР СУМЫН 5 ДУГААР ЦЭЦЭРЛЭГ

2017-2018 оны хичээлийн жилд 324 хүүхэд, 25 багш, ажилчидтай 329795,7 мянган төгрөгийн батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Аймгийн Засаг даргаас Боловсрол, соёл урлагийн газрын дарга, тавдугаар цэцэрлэгийн эрхлэгчийн хооронд гурвалсан гэрээг 5 зорилт 45 арга хэмжээтэй байгуулсан.

Ололттой тал:

Байгууллагын жилийн ажлын төлөвлөгөөг задалж багш бүрээр сарын ажлын төлөвлөгөө гаргаж батлуулдаг. Мөн сар бүр хэрэгжилтийг тайлагнаж, үр дүнг тооцож ажилладаг.

Бодлогын баримт бичгүүдээс хамааралтай зорилт арга хэмжээг хяналтанд авч тайлагнасан.

Дутагдалтай талууд:

1. Ажлын байрны тодорхойлолт нь багш бүр нэгэн ижил, албан тушаал бүрт ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах шаардлагатай. Жишээ нь: 2 настай, 5 настай хүүхдийн ангийн багш хэрэгжүүлэх чиг үүрэг ижил байна. Явуулах сургалтын хөтөлбөр өөр байх учир ажлын байрны тодорхойлолт ч мөн адил өөр баймаар байна.

2. Байгууллагын багш, ажилчдын хувийн хэргийн бүрдэл дутуу, хувь хүний намтар зааврын дагуу бичигдээгүй.

3. Дотоод хяналтыг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлж ажилласан боловч төлөвлөсөн арга хэмжээ бүрт удирдамж гаргаж батлуулаагүй.

12. АЙМГИЙН БОРЖИГИН ӨВ МУЗЕЙ

Боржигин өв музей нийт 9 ажилтан албан хаагчтай. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, соёл урлагийг хөгжүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх, төрийн албан хаагчийн харилцаа хандлага ёс зүйг сайжруулах зэрэг дэд хөтөлбөрүүдээс холбогдох заалтыг авч төлөвлөлтийг хийж албан хаагчдад эзэнжүүлсэн байна.

Ололттой тал:

- ✚ Ажлын байрны тодорхойлолт бүрэн.
- ✚ Төрийн албан хаагчийн хувийн хэргийн бүрдүүлэлт сайн.
- ✚ Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг байгууллагын даргын 2017.06.13-ны А/11 тоот тушаалаар 16 арга хэмжээ бүхий төлөвлөгөөтэй баталсан. Төлөвлөгөө хяналттай.
- ✚ Байгууллагын албан хаагчид бүгд хөдөлмөрийн гэрээгээ байгуулсан. Хөдөлмөрийн гэрээг сар бүр дүгнэж, улирлаар цалин сандаа багтааж урамшил олгодог.
- ✚ Байгууллагад хөтлөгдөж буй дотоод баримт бичиг эмх цэгцтэй.

Дутагдалтай тал:

1. Төрийн албан хаагчийн хувийн хэргийн хувь хүний намтрыг санамжийн дагуу бичээгүй.

13. АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САН

2017 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын ажил

- ✚ ОНХСангийн санхүүжилтээр 5,0 сая төгрөгийн 339 ном
- ✚ Яамны санхүүжилтээр 3,0 сая төгрөгийн 159 ном
- ✚ Байгууллагын төсвөөс 2.466.000 мян.төгрөгөөр 288 ном нийт 726 ном худалдан авсан.

Дутагдалтай талууд:

1. Ажлын байрны тодорхойлолтын ажилтны нэрээр нь баталсан байна. Ажлын байрны тодорхойлолт нь албан тушаалд тохирсон байх шаардлагатай тул шинэчлэн боловсруулах шаардлагатай.
2. Төрийн албан хаагчийн хувийн хэргийн бүрдэл дутуу, хувь хүний намтар бичих зааврын дагуу бичигдээгүй.
3. Төлөвлөгөөг батлахдаа хэзээ батлагдсан нь тодорхойгүй, өөрөөр хэлбэл он, сар, өдрийг тодорхой оруулаагүй байсан.
4. Сарын ажлын төлөвлөгөө гаргадаг боловч хэрэгжилтийн явц, гүйцэтгэлийг үнэлдэггүй.

14. АЙМГИЙН БОРЖИГИН ЧУУЛГА

Аймгийн Засаг даргын сайдтай байгуулсан гэрээ, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн соёл урлагийг хөгжүүлэх дэд хөтөлбөр, аймгийн хөгжлийн цогц бодлого зэрэг баримт бичгүүдээс холбогдох арга хэмжээг хяналтанд авсан байна.

Дутагдалтай талууд:

1. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг буруу үнэлгээгээр тооцсон.
2. Тушаал гаргахдаа холбогдох хуулийн зүйл заалтыг оновчтой үндэслээгүй

3. ДҮГНЭЛТ, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Боловсрол, соёл урлагийн газар болон харьяа байгууллагуудад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ илэрсэн алдаа дутагдлыг арилгах зорилгоор тухайн байгууллагын захирал, эрхлэгч болон холбогдох мэргэжилтэн нарт арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Боловсрол, соёл урлагийн газраас хагас, бүтэн жилээр харьяа байгууллагуудад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийдэг боловч байгууллагын дотоод үйл ажиллагааны үндсэн хэсэг болох баримт бичгийн төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналт, хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолт зэргийг үзэж арга зүйгээр хангадаггүй учраас дээрх байгууллагуудад нийтлэг алдаа гарч байна гэж дүгнэж байна.

Иймд салбарын үйл ажиллагааг сайжруулж ажиллахад дараах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй. Үүнд:

1.Боловсрол, соёл урлагийн газар нь байгууллага нь дараах арга хэмжээ бүрийг гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөнд тусгаж, илэрсэн алдаа дутагдлыг арилган төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллахад анхаарах.

1. Жил бүрийн эхэнд бодлогын баримт бичгүүдээс холбогдолтой зорилт, арга хэмжээг хяналтад авч төлөвлөлт хийн, харьяа байгууллагуудад эзэнжүүлэх,
2. Байгууллагуудын албан хаагчдын хувийн хэргийг Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 18 дугаар тогтоолын дагуу бүрэн бүрдүүлэх
3. Төрийн албан хаагч бүртэй үр дүнгийн гэрээ байгуулж, үр дүнг тооцож ажиллах,
4. Байгууллагын ажилтан, албан хаагчдын ажил үүргийг тэнцвэржүүлэх зорилгоор ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж батлах,
5. Салбарын хүрээнд ажиллаж байгаа болон цаашид шаардлагатай байгаа албан тушаалын судалгааг гаргах, мэдээллийн сан үүсгэх
6. Байгууллагын боловсон хүчний тогтвортой байдлыг хангах, сул орон тоон дээр төрийн жинхэнэ албаны шалгалт өгч тэнцсэн албан хаагчдыг авч ажиллуулах, тэнцээгүй албан хаагчийг ажиллуулахгүй байх зарчмыг баримтлах,
7. Байгууллагын цахим хуудасны мэдээллийг бүрэн оруулж, иргэдэд нээлттэй ил тод байдлыг хангах
8. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод хяналтын ажилтныг томилж, дотоод хяналтыг эрчимжүүлж ажиллах

2.Салбарын хүрээнд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэх ажиллаж илэрсэн дутагдлыг арилгахад арга зүйгээр хангаж, зөвлөмжийг хэрэгжүүлэх гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө гаргаж, хяналт тавьж ажиллах

1. Харьяа байгууллагуудад хийх хяналт-шинжилгээ, үнэлгээний журмыг шинэчлэн боловсруулж батлах
2. Харьяа байгууллагуудын хоорондын уялдаа холбоог хангах, хамтын ажиллагааны төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг тооцож ажиллах
3. Сургууль, цэцэрлэгийн багш нарын ажлын байрны тодорхойлолтыг тухайн албан тушаалд тохируулан боловсруулж батлуулах,
4. Сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагын ажилтан, албан хаагчдын хувийн хэргийг Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 18 дугаар тогтоолын дагуу бүрэн бүрдүүлэхэд анхаарах

5. Хуваарь гаргаж харьяа байгууллагуудын тушаалын эрх зүйн үндэслэлийг хянаж, хууль эрх зүйн зөвлөгөө өгч ажиллах, зөрчлийг арилгуулж, хуулийн үндэслэлтэй шийдвэр гаргахад хяналт тавих

6. Бодлогын баримт бичгийн тайлангийн чанарт анхаарах, хэрэгжилтийг хэрэгжүүлэх арга хэмжээнд дүйцүүлж тайлагнах, гүйцэтгэлийн үнэлгээг зөв аргачлалаар тооцох

7. Төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээний тухай, Хөдөлмөрийн гэрээний тухай, Төрийн албан хаагчийн хувийн хэрэг бүрдүүлэх журмын чиглэлээр нэгдсэн сургалтыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулж, захирал, эрхлэгч нарыг бүрэн хамруулах

8. Ажлын байрны тодорхойлолт боловсруулах аргачлал, бодлогын баримт бичгийн төлөвлөлт, гүйцэтгэл сэдвээр сургалт зохион байгуулж, харьяа байгууллагын захирал, эрхлэгч, албан хаагчдыг арга зүйгээр хангах

9. Харьяа байгууллагуудын захирал, эрхлэгч нарын эрх мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарч Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль гэх мэт шаардлагатай хууль тогтоомжийн талаар сургалт зохион байгуулах

10. Хамран сургах тойргийг сургууль цэцэрлэгүүдэд шинэчлэн тогтоож өгөх

11. Хяналт шинжилгээ, үнэлгээгээр харьяа байгууллагуудаараа ажилласан тохиолдолд илтгэх хуудас заавал бичиж, зөвлөмжийг албан тоотоор хүргүүлэх

12. Сургууль, цэцэрлэгийн бэлгэдэл, тугийг АИТХ-д өргөн мэдүүлж, баталгаажуулж өгөх.

Дээрх 2 хэсгийн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж биелэлтийг 10 дугаар сарын 01-ний дотор гаргаж албан бичгээр аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэст ирүүлж ажиллах нь зүйтэй.

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХШУДАХ-ИЙН ДАРГА

Х.БУЯНБАЯР

ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

П.НАРАНМАНДАХ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Б. ӨЛЗИЙДЭЛГЭР